Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	**3.5**	**35**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	0.5	5
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**2.5**	**25**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9**	**90**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.

[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.

[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”.

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар “Сургалтын агуулга, сэдэв батлах тухай” тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.

[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.

[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.

[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН[1]

НЭГ. Товч танилцуулга[2]

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын дагуу Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдийг сонгон шалгаруулах ажлыг 430 албан хаагчийн дунд зохион байгуулан хамгийн өндөр саналаар Үндэсний аудитын газрын Тамгын дарга, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, арга зүй хариуцсан менежер П.Цэнгүүн, Ахлах аудитор У.Оюунхүү, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ч.Цагаанхүү, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нарын 7 албан хаагч сонгогдсон.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/104 дүгээр тушаалаар "Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дэд хороо"-ны бүрэлдэхүүнийг батлснаар Ёс зүйн дэд хорооны анхдугаар хуралдаанаа 2024 оны 12 дугаар 25-ны өдөр зохион байгуулсан. Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дэд хорооны даргаар Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, нарийн бичгийн даргаар Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын Арга зүй хариуцсан менежер П.Цэнгүүн нар сонгогдсон. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг сонгосон шийдвэр албан ёсоор баталгаажсан.

Ёс зүйн дэд хороо Төрийн албаны төв байгууллагын дэргэд байгуулагдсан Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүдтэй албан ёсны уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулав.

Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж гишүүдэд урьдчилан тарааж 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Ёс зүйн дэд хорооны хурлаар төлөвлөгөөний төслийг хэлэлцлээ. Гишүүдийн өгсөн саналыг төлөвлөгөөнд тусгаж 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Ёс дэд хорооны дарга "ТАБ-ын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөө"-г тус тус батлсан ба хэрэгжилтийг ханган ажиллав.

АТГ-аас төрийн зарим байгууллагуудад авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авлигын эсрэг сургалт, сурталчилгааг зохион байгуулах сургагч багш нарыг бэлтгэж, үйл ажиллагаандаа татан оролцуулах зорилго бүхий "Авлигын эсрэг сургагч багш бэлтгэх сургалт"-ыг зохион байгуулсан бөгөөд тус сургалтад ЭУГ-ын захирал Д.Отгонбаяр, Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ч.Алтансүх, шинжээч Б.Анудар 2025 оны 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд хамрагдаж 2 албан хаагч сургагч багшийн гэрчилгээ авсан.

---

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

МУ-ын Ёс зүйн хороо, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан “Ёс зүйн сургагч багш бэлтгэх” анхан шатны хөтөлбөрт 2025 оны 05 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Ёс зүйн дэд хорорны гишүүн Ч.Цагаанхүү, нарийн бичгийн дарга П.Цэнгүүн нар амжилттай хамрагдаж, сургагч багшийн сертификат гардан авсан.

Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо” цахим системийн “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт дэд систем”-д Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний мэдээллийг боруулсан. Мөн ТАБ-ын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон сургалтын төлөвлөгөөг тус тус дэлгэрэнгүй хэлбэрээр тус системд байршуулсан.

Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг бэлтгэсэн. Мөн 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг МУ-ын Ёс зүйн хороонд гарган 2026 оны 01 дүгээр сарын 05-нд хүргүүлсэн болно.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:

ТАБ-ын албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж албан хаагчдын суурин компьютерийн дэлгэц дээр “ТАБ-ын Ёс зүйн дэд хорооноос сануулж байна” нэртэйгээр төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, мөрдөх хэм хэмжээ, хориглох үйл ажиллагааны заалтуудаар танилцуулга бэлтгэж I, II, IY улиралд буюу нийт 3 удаа шинэчилж албан хаагчдад соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулжээ.

Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дэд хорооноос цуврал сургалтын хүрээнд зорилтот бүлэг, сэдвийн агуулгаас хамааран дараах 5 сургалт зохион байгуулсан. Үүнд:

- ТАБ-ын Удирдах албан хаагчдын 2025 оны зөвлөгөөн 2025 оны 02 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба МУ-ын Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс УАГ-ын бүтцийн нэгж, аймаг нийслэл дэх ТАГ-ын захирал нийт 50 албан хаагчдад зориулж “Төрийн албаны ёс зүйн тухай хууль, тогтоомж” сэдвээр илтгэл тавьсан.
- Гэрээгээр санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэж байгаа аудитын хуулийн этгээдүүдийн аудиторуудад зориулсан сургалтад “ТАБ-ын албан хаагчийн мөрдөх ёс зүйн хууль тогтоомж, анхаарах асуудал” сэдэвт сургалтыг танхимын хэлбэрээр 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга П.Цэнгүүн танилцуулсан. Энэхүү сургалтад 64 аудитын хуулийн этгээдийн нийт 285 аудитор оролцсон байна.
- “ТАБ-ын албан хаагчийн мөрдөх ёс зүйн хууль тогтоомж, анхаарах асуудал” сэдэвт сургалтаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, АДБОУС 130 “Ёс зүйн стандарт”, “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн мөрдөх ёс зүйн дүрэм”-ийг тус тус бүх албан хаагчдад таниулах сургалтыг цахим хэлбэрээр ТАБ-ын нийт 378 албан хаагчдад 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга П.Цэнгүүн зохион байгуулсан.
- “Ёс зүйн тухай ойлголт” сэдэвт сургалтыг аймаг дахь ТАГ-ын нийт албан хаагчдад цахим хэлбэрээр Ёс зүйн дэд хорооны гишүүн Б.Болортуул 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав.
- ТАБ-д шинээр томилогдсон албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, ТАБ-ын албан хаагчийн мөрдөх ёс зүйн дүрмийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилго бүхий цуврал сургалтуудын эхний сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Ёс зүйн дэд хорооны гишүүн Б.Бундхорол танилцуулсан. Тус сургалт нийт 102 шинээр томилогдсон албан хаагчид оролцохоос 89 албан хаагч оролцож ирц 87 хувь байсан.

- Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд зориулан "Төрийн аудиторын ёс зүй" 3 кредит цагийн агуулга бүхий 12 сэдэвт цахим сургалтын эрхийг "Нээлттэй сургалтын хөтөлбөр"-өөс 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр цахим сургалтын нээлттэй эрх үүсгэснээр ажлын хэрэгцээнд шаардлагатай үед нэвтрэн орж үзэх боломжоор хангагдсан.

Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийж тайлагнах арга хэмжээний хүрээнд Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дэд хороо, Эрсдэлийн удирдлагын газартай хамтран "Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ"-г хийж судалгааны ажлын тайлан бэлтгэж боловсруулан судалгааны дүнг Ёс зүйн дэд хорооны 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэв. "Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ"-ний судалгааны тайлантай болсноор ТАБ ёс зүн чиглэлээр суурь судалгаатай болж цаашид энэхүү судалгааны ажил дээр суурилан гүнзгийрүүлэн дүн шинжилгээ, судалгаа хийснээр ёс зүйтэй холбоотой бичиг баримтуудыг шинэчлэх боломжтой болж байна.

"Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн мөрдөх ёс зүйн дүрэм"-ийн Хавсралтаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах тухай мэдэгдэл"-ийг шинэ албан хаагчдаар баталгаажуулж, хувийн хэрэгт нь тухай бүр хавсарган ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн төлөвшил, байгууллагын нээлттэй соёлыг хэвшүүлэхийн тулд МУ-ын Ерөнхий аудитор "Төрийн аудитын байгууллагын шинэ ажилтныг чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. **"Шинэ ажилтныг чиглүүлэх хөтөлбөр"**. Энэхүү хөтөлбөр нь эхний 1-2 хоногт багтаан хэрэгжүүлдэг хөтөлбөр юм. Үүнд шинэ ажилтныг угтаж авах, шинэ ажилтанд байгууллагын зохион байгуулалт, чиг үүрэг, хэм хэмжээг танилцуулах зорилготой хөтөлбөр юм.
2. "**Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөр".** Тус хөтөлбөрийг эхний 3 дахь хоногоос эхлэн 3 хүртэл сарын хугацаанд хэрэгжүүлдэг. Шинэ ажилтанд дадлагажуулагч томилох ба дадлагажуулагч шинэ ажилтныг дадлагажуулах, дэмжлэг үзүүлэх, сургаж хөгжүүлэх үүргийг хүлээдэг. Хөтөлбөрийн хугацаа дуусахад "Дасан зохицох дадлагын үнэлгээний хуудас"-аар дадлагажуулагч үнэлгээ өгснөөр хөтөлбөр дуусгавар болдог.

Тус хөтөлбөрийн зорилго нь шинэ ажилтанд төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, зорилго, зорилт, чиг үүрэг, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, хөдөлмөрийн нөхцөл болон албан хаагчийн дагаж мөрдөх дүрэм, журам, байгууллагын соёл, үйл ажиллагааны талаар нэгдсэн ойлголт өгөх, чиглүүлэх, богино хугацаанд дадлагажуулах, хүний нөөцийн тогтвортой үйл ажиллагааг хангахад оршиж байна.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

"Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх журам"-ын 11 дүгээр Хавсралтаар ТАБ-ын удирдах ажилтны "Үүрэг хариуцлага ба ёс зүйн баталгаа"-г батлан мөрдүүлэн ажиллаж байна. Удирдах албан тушаалтан энэхүү маягтыг бөглөн МУ-ын Ерөнхий аудитораар баталгаажуулдаг. "Үүрэг хариуцлага ба Ёс зүйн баталгаа"-ны үнэлгээг МУ-ын Ерөнхий аудитор эсхүл түүний байгуулсан ажлын хэсгийн үнэлгээгээр хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж улирал бүр гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээтэй нэгтгэж, нэгдсэн үнэлгээг гаргадаг. Ингэснээр удирдах түвшний албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, чигч шударга байдлыг хөхиүлэн

дэмжих, ёс зүйн манлайллыг бий болгох, үнэлэх тогтолцоог төлөвшүүлэхэд үр нөлөөтэй арга хэрэгсэл болж байна.
Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, ажиллах нөхцөл, гишүүдийн урамшууллын санхүүгийн эх үүсвэрийг бүрэн шийдвэрлэснээр гишүүд, нарийн бичгийн дарга улирал болон сар бүр урамшууллаа бүрэн авсан.
Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн шинж байдалд нийцүүлэн ёс зүйн хариуцлагыг хүлээлгэсэн буюу 4 албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн.

Төрийн албаны зөвлөл, МУ-ын Ёс зүйн хорооноос хамтран зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" нийслэлийн зөвлөгөөнд Ёс зүйн дэд хорооны дарга Ц.Наранчимэг, нарийн бичгийн дарга П.Цэнгүүн нар 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр оролцов.
ТАБ-ын audit.mn цахим хуудасны "Ёс зүй" цэс болон байгууллагын албан ёсны нүүр хуудсанд цаг үеийн үйл явдлын дараах мэдээ, мэдээллийг байршуулсан. Үүнд:

- ТАБ-ын Ёс зүйн дэд хороо анхдугаар хуралдааныг зохион байгуулсан тухай;
- "ТАБ-ын Ёс зүйн дэд хороо Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулагдсан МУ-ын Ёс зүйн хороотой уулзалт зохион байгуулсан тухай;
- ТАБ-ын албан хаагчийн Ёс зүйн дүрэм;
- ТАБ-ын Ёс зүйн дэд хорооны I улирлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцсэн хуралдааны мэдээлэл.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Тайлант хугацаанд нийт 11 албан хаагчтай холбоотой 8 гомдол, мэдээллийг иргэн, албан хаагч, шалгагдагч байгууллагаас ирүүлснийг хүлээн авч 7 албан хаагчидтай холбогдох 4 гомдлыг хянан шалгаж шийдвэрлэсэн байна. Үүнд:

- ҮАГ-ын СНАГ-ын нэр бүхий албан хаагчидтай холбоотой гомдол 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр ирсэн ба гомдлыг Ёс зүйн дэд хорооны гишүүн Б.Бундхорол, гишүүн Д.Энхболд нар шалгаж, 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн дэд хорооны хуралдаанд шалгалтын дүнг танилцуулж, ёс зүйн зөрчил биш гэж үзэн дэд хорооны шийдвэрийг гомдол гаргагчид цахим хаягаар хүргүүлж мэдэгдсэн.

- Дундговь аймаг дахь ТАГ-ын нэр бүхий албан хаагчдын талаар гомдол ирснийг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Чанарын удирдлагын газраас гомдолд дурдсан зарим асуудлыг ёс зүйн зөрчил гэж үзэн дэд хороонд дотоод албан бичгээр шилжүүлсэн. Тус гомдлыг дэд хорооны гишүүн Б.Бундхорол, нарийн бичгийн дарга П.Цэнгүүн нар шалгаж, 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанд шалгалтын дүнг танилцуулж, "Ёс зүйн зөрчил гаргасан", "Дундговь аймаг дахь ТАГ-ын үйл ажиллагааг шалгах ажлын хэсэг байгуулах" дүгнэлт гарсан болно. Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг гомдол гаргасан этгээд, зөрчилд холбогдсон албан хаагч, томилох эрх бүхий албан тушаалтанд дүгнэлтийг хүргүүлж мэдэгдсэн. Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн МУ-ын Ерөнхий аудитор ёс зүйн зөрчил гаргасан 2 албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн.

- Булган аймаг дахь ТАГ-ын нэр бүхий албан хаагчийн талаар 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдөр гомдол ирснийг Ёс зүйн дэд хороонд шилжүүлж дэд хорооны гишүүн У.Оюунхүү, нарийн бичгийн дарга П.Цэнгүүн нар тус гомдлыг шалгаж, шалгалтын дүнг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд шалгалтын дүнг танилцуулж, "Ёс зүйн зөрчил гаргасан" гэсэн дэд хорооны дүгнэлт гарч гомдол гаргасан этгээд, зөрчилд холбогдсон албан хаагч, томилох эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн. Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн МУ-ын Ерөнхий аудитор ёс зүйн зөрчил гаргасан 1 албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн.

- Архангай аймаг дахь ТАГ-ын нэр бүхий албан хаагчтай холбоотой олон нийтийн сүлжээний хэрэгсэлд тавигдсан асуудлаар мэдээлэл ирснийг дэд хорооны 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж "Ёс зүйн зөрчил гарсан" гэсэн дүгнэлт гарч, дэд хорооны шийдвэрийг томилох эрх бүхий албан

хаагч болон зөрчилд холбогдсон албан хаагчид тус тус мэдэгдсэн. Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн МУ-ын Ерөнхий аудитор ёс зүйн зөрчил гаргасан 1 албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн.

Дараах 4 гомдлыг хянан шалгах ажиллагаа явагдаж байгаа ба шалгалтын дүн хараахан гараагүй байна. Үүнд:

- Баян-Өлгий аймаг дахь ТАГ-ын нэр бүхий албан хаагчтай холбоотой гомдол 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр ирснийг бүртгэж, гишүүн Д.Энхболд, Ч.Цагаанхүү нарт гомдлыг хуваарилан хянан шалгах ажиллагаа явагдаж байна.
- Нийслэл дэх ТАГ-ын нэр бүхий албан хаагчтай холбоотой гомдол 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр ирснийг бүртгэж, гишүүн У.Оюунхүү, нарийн бичгийн дарга П.Цэнгүүн нарт гомдлыг хуваарилан гомдлыг шалгах ажиллагаа явагдаж байна.
- УАГ-ын Тамгын газрын нэр бүхий албан хаагчтай холбоотой гомдол 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр ирснийг бүртгэж, гишүүн Б.Болортуул, нарийн бичгийн дарга П.Цэнгүүн нар гомдлыг хянан шалгаж 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн дэд хорооны хуралдаанаар шалгалтын дүнг танилцуулж, нотлох баримтыг иж бүрэн цуглуулж шалгахаар шийдвэрлэж шалгах ажиллагаа явагдаж байна.
- УАГ-ын Чанарын удирдлага, эрсдэлийн газрын нэр бүхий албан хаагчтай холбоотой гомдол 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр ирснийг бүртгэн, гишүүн Д.Энхболд, Ч.Цагаанхүү нарт хуваарилагдан гомдлыг шалгах ажиллагаа явагдаж байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2 гишүүн МУ-ын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Ёс зүйн сургагч багш”-ийн анхан шатны хөтөлбөрт хамрагдсанаар ёс зүйн дэд хорооны гишүүдийн чадавх бэхжиж, албан хаагчдад сургалт зохион байгуулах чадавхтай болсон. “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ”-ний судалгааг анх удаа хийснээр суурь судалгаатай болж цаашид энэхүү судалгааны ажил дээр суурилан бусад төрлийн судалгаа, дүн шинжилгээ, ёс зүйтэй холбоотой бичиг баримтуудыг шинэчлэх боломжтой болж байна.	Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд ёс зүйн дэд хорооны дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнахад асуудал үүсэж байна. Учир нь нь дэд системд гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээллийг оруулахад гомдол гаргагчийн регистрийн дугаарыг заавал оруулах шаардлага тавигддаг. Гэтэл гомдол гаргагч хувь хүний мэдээллийг нэхэж, шаардаж байна хэмээн дургүйцэж мэдээллээ өгөхгүй байгаа учраас дэд системд гомдол, түүний шийдвэрлэлтийн талаар бүртгэлийг одоог хүртэл оруулж чадахгүй хүндрэл бэрхшээл үүсээд байна.
Санал:	
1.МУ-ын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ыг хэрхэн ашиглаж судалгаа хийх талаар Ёс зүйн дэд хорооны бүх гишүүдэд сургалт зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна. 2. Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд гомдол мэдээлэл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх бүртгэлийг оруулахдаа гомдол гаргагчийн регистрийн дугаарыг оруулахгүй байж болох сонголттой болгох буюу, регистрийн дугаарыг оруулаагүй тохиолдолд бүртгэлийг оруулах боломжтой байхаар дэд системд зохицуулалтыг хийж өгөх хүсэлтийг уламжилж байна. Учир нь дэд системд гомдол гаргагчийн регистрийн дугаарыг оруулаагүй бол бүртгэлийг цаашид үргэлжлүүлэх боломжгүйд хүрдэг.	

Шалгах хэсэг:

☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР С.МАГНАЙСҮРЭН

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР П.ЦЭНГҮҮН

2026.01.05

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Гүйцэтгэлийн удирдлагын баримт бичиг

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГУУЛЛАГЫН НЭР: **ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

БАТЛАВ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА..... ..... **Ц.НАРАНЧИМЭГ**
(албан тушаал) *(гарын үсэг)* *(нэр)*

Тамга

2025.01.20.
(огноо)

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа (улирлаар)				Төсөв (мян.төг)	Хариуцах гишүүн	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		
		I	II	III	IY			**Шалгуур үзүүлэлт** *(Үйл ажиллагаа болон бодлого, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлт)*	**Суурь түвшин** *(Үйл ажиллагаа болон бодлого, арга хэмжээний хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утга)*	**Хүрэх түвшин** *(Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утга)*
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Нэг. Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоох ажлын хүрээнд										
1	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	2025.01.02 2025.03.31				Батлагдсан төсвийн хүрээнд	П.Цэнгүүн	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан санал авч баталсан байх	ТАБ-ын Ёс зүйн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулж байсан.	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
2	“ТАБ-ын албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулж батлуулах		2025.04.01 2025.06.30			Батлагдсан төсвийн хүрээнд	Б.Бундхорол ТГ Ёс зүйн дэд хороо	Хуульд нийлцүүлэн шинэчлэн боловсруулж батлуулсан байх	2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн МУ-ын Ерөнхий аудиторын А/52 дугаар тушаалаар баталсан “ТАБ-ын албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдөн ажиллаж байна.	2023 оны 05 дугаар сарын 04-ны өдөр баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-д нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулсан “ТАБ-ын албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг баталсан байна.

3	“ТАБ-ын албан хаагчийн ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг”-ийн маягтыг шинээр боловсруулж батлуулах		2025.04.01 2025.06.30			Батлагдсан төсвийн хүрээнд	Ц.Наранчимэг Б.Болортуул П.Цэнгүүн ТГ	1)Мэдүүлгийн маягтыг шинэчлэн боловсруулж, батлуулсан байх 2) Мэдүүлэг гаргасан байх албан хаагчдын тоо	ТАБ-ын албан хаагчийн ёс зүйн дүрмийн Хавсралт А “ТАБ-ын албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах тухай мэдэгдэл” баталж мөрдөж байсан.	Мэдүүлгийн маягтыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.
4	Төрийн аудитын байгууллагын шударга байдлын үнэлгээ хийж, журмыг боловсруулан батлуулж мөрдөх, үр дүнг тайлагнах;	2025.01.02 2025.03.31	2025.04.01 2025.06.30	2025.07.01 2025.09.30	2025.10.01 2025.12.26	Батлагдсан төсвийн хүрээнд	Б.Бундхорол ТГ Зорилтын ажлын хэсэг	1) Шударга байдлын үнэлгээ 2) Шударга байдлын журам	0	1)Шударга байдлын үнэлгээний тайлан 2) Шударга байдлын журам боловсруулж, баталсан байна.
Хоёр. Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд										
5	ТАБ-ын албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор цахим мэдээлэл, танилцуулга бэлтгэж нийт албан хаагчдад түгээх	2025.01.02 2025.03.31	2025.04.01 2025.06.30	2025.07.01 2025.09.30	2025.10.01 2025.12.29	Батлагдсан төсвийн хүрээнд	Ц.Наранчимэг Д.Энхболд Б.Болортуул Ч.Цагаанхүү ТГ МТНТ	1)Байгууллагын Able программд байршуулах цахим мэдээлэл, танилцуулгын тоо 2) Танилцсан албан хаагчдын тоо	ТАБ-ын нийт албан хаагчдад зориулж цахим мэдээлэл бэлтгэж байгууллагын Able программд байршуулж байсан.	1) Байгууллагын Able программд цахим мэдээлэл, танилцуулга бэлтгэж байршуулсан байна. 2) 4
6	Нийт албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт зохион байгуулах, арга зүйн зааврааар хангах	2025.01.02 2025.03.31	2025.04.01 2025.06.30	2025.07.01 2025.09.30	2025.10.01 2025.12.29	Батлагдсан төсвийн хүрээнд	Ёс зүйн дэд хороо СТГ	1)Танхим, эсхүл цахим сургалтын тоо 2) Сургалтад хамрагдах албан хаагчдын тоо	“Төрийн аудиторын ёс зүй” нэртэй 12 сэдвийн хүрээнд 3 кредит 48 цагийн хичээл сургалт, хөгжлийн системд байршсан.	1) Сургалтын тоо-7 2) Сургалтад хамрагдсан ажилтны тоо-530

7	ТАБ-д шинээр орсон ажилтанд ёс зүйн чиглүүлэх сургалт зохион байгуулах		2025.04.01 2025.06.30		2025.10.01 2025.12.29	Батлагдсан төсвийн хүрээнд	Б.Бундхорол СТГ	1)Танхим, эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах сургалтын тоо 2) Хамрагдах албан хаагчдын тоо	ТАБ-ын дүрэм журам, ёс зүй, нөлөөллийн мэдүүлгийн журмыг танилцуулах сургалтыг зохион байгуулсан.	1)Зохион байгуулсан сургалтын тоо-2 2) Хамрагдсан албан хаагчдын тоо-100
8	Нэмэлт өөрчлөлт орсон “ТАБ-ын албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг албан хаагчдад сурталчлан таниулах			2025.07.01 2025.09.30			Б.Бундхорол П.Цэнгүүн СТГ	1)Танхим, эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах сургалтын тоо 2) Хамрагдах албан хаагчдын тоо	“ТАБ-ын албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг нийт албан хаагчдад сурталчлан таниулсан сургалт зохион байгуулсан.	Зохион байгуулсан сургалтын тоо-1 Хамрагдсан албан хаагчдын тоо-530
9	Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй сургалтад хамруулах	2025.01.02 2025.03.31	2025.04.01 2025.06.30	2025.07.01 2025.09.30	2025.10.01 2025.12.29	Батлагдсан төсвийн хүрээнд	Ц.Наранчимэг Б.Бундхорол ТГ	1)Танхимын болон цахим сургалт 2) 2	0	Хамрагдсан сургалтын тоо-2 Хамрагдсан албан хаагчдын тоо-5
10	Ёс зүйн дүрмийн хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах тухай мэдэгдэл”-ийг нийт албан хаагчдаар баталгаажуулж хувийн хэрэгт хавсаргах ажлыг зохион байгуулах	2025.01.02 2025.03.31				Батлагдсан төсвийн хүрээнд	ТГ ЗББН	1)Мэдэгдэл гаргаж хувийн хэрэгт хавсаргасан ажилтны эзлэх хувь	ТАБ-ын албан хаагч бүр ёс зүйн дүрмийг мөрдөх баталгааны хуудсанд гарын үсэг зурж, хувийн хэрэгт нь баяжилт хийсэн.	Мэдэгдэл гаргаж хувийн хэрэгт хавсаргасан ажилтны эзлэх хувь-100

Гурав. Зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах ажлын хүрээнд

11	Албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл ирсэн тохиолдолд дэд хорооны хурлаар хэлэлцэж дүгнэлт гарган, Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулах	2025.01.02 2025.03.31	2025.04.01 2025.06.30	2025.07.01 2025.09.30	2025.10.01 2025.12.29	Батлагдсан төсвийн хүрээнд	Ц.Наранчимэг П.Цэнгүүн	1)Ирсэн гомдол, мэдээллийн тоо 2) Ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийн тоо	ТАБ-ын 19 албан хаагчтай холбоотой 17 гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн.	ТАБ-ын Ёс зүйн дэд хороонд гомдол, мэдээлэл ирсэн тохиолдолд тухай бүр хүлээн авч, хянан шалгаж, шийдвэрлэж хариуг өгсөн байдал-100%
Дөрөв. Албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ, судалгаа хийх ажлын хүрээнд										
12	ТАБ-ын хэмжээнд гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг судалж, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, танилцуулах		2025.04.01 2025.06.30			Батлагдсан төсвийн хүрээнд	Б.Болортуул Ч.Цагаанхүү У.Оюунхүү ЧУГ	ТАБ-ын хэмжээнд гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, нөхцөл байдал, хүчин зүйлсийн талаарх тайлан, танилцуулга	0	ТАБ-ын хэмжээнд гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг судалж, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон тайлан, танилцуулга-1
13	Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийж тайлагнах	2025.01.02 2025.03.31				Батлагдсан төсвийн хүрээнд	Д.Энхболд У.Оюунхүү ЭУГ	1)МУ-ын Ёс зүйн хорооноос баталсан аргачлал 2) Үнэлгээний тайлан, танилцуулга	0	Үнэлгээний тайлан, танилцуулга-1
14	Төрийн аудитын байгууллагын албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор Ёс зүйн дэд хороонд ирсэн гомдол, мэдээлэлд үндэслэн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийж нөхцөл байдлыг танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулах				2025.10.01 2025.12.26	Батлагдсан төсвийн хүрээнд	Ц.Наранчимэг Ч.Цагаанхүү ТГ	1)Дүн шинжилгээ, нөхцөл байдлын тайлан 2) Албан хаагчдын дунд зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо 3)Хэлэлцүүлэгт хамрагдсан албан хаагчдын тоо	0	1)Дүн шинжилгээ, нөхцөл байдлын тайлан-1 2) Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо-1 3) Хэлэлцүүлэгт оролцох албан хаагчдын тоо-30

15	Харилцагч тал, шалгагдагч этгээдээс албан хаагчийн ёс зүйн асуудлаар санал асуулга авч нэгтгэж, тайлагнан, холбогдох нэгжүүдэд зөвлөмж хүргүүлэх			2025.07.01 2025.09.30		Батлагдсан төсвийн хүрээнд	Ц.Наранчимэг Б.Болортуул П.Цэнгүүн ЧУГ	1) Санал асуулгыг нэгтгэсэн судалгааны тайлан 2) Холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн зөвлөмжийн тоо	0	1)Судалгааны тайлан-1 2)Холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн зөвлөмжийн тоо-2
Тав. Ёс зүйн зөрчлийг бүртгэх, тайлагнах, мэдээлэх ажлын хүрээнд										
16	Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан, мэдээг МУ-ын Ёс зүйн хороонд хүргүүлэх	2025.01.02 2025.03.31	2025.04.01 2025.06.30	2025.07.01 2025.09.30	2025.10.01 2025.12.29	Батлагдсан төсвийн хүрээнд	П.Цэнгүүн	1)Ёс зүйн дэд хорооны ажиллах журам 2) Ёс зүйн хороонд хүргүүлсэн тайлан, мэдээний тоо	МУ-ын Ёс зүйн хороонд 2024 оны жилийн эцсийн тайлан, мэдээг гаргаж хүргүүлсэн.	1)Тайлан, мэдээг хүргүүлсэн байдал, хувь-100% 2)Тайлан, мэдээ хүргүүлсэн тоо-4
17	ТАБ-ын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг бэлтгэж Ёс зүйн хороонд хүргүүлэх	2025.01.02 2025.03.31				Батлагдсан төсвийн хүрээнд	П.Цэнгүүн	1)Ёс зүйн дэд хорооны ажиллах журам 2) ТАБ-ын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан 3) 1	ТАБ-ын Ёс зүйн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг МУ-ын Ёс зүйн хороонд хүргүүлсэн.	1)ТАБ-ын Ёс зүйн дэд хорооны тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна. 2)Тайлангийн тоо-1
18	Ёс зүйн гомдол, мэдээлэл, гаргасан дүгнэлт, ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийг “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо” цахим системд бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлэх	2025.01.02 2025.03.31	2025.04.01 2025.06.30	2025.07.01 2025.09.30	2025.10.01 2025.12.29	Батлагдсан төсвийн хүрээнд	П.Цэнгүүн	1)Ёс зүйн дэд хорооны ажиллах журам 2) Төрийн албаны ХНУМТ цахим системд мэдээлэл байршуулсан байдал, хувь	0	Системд мэдээлэл байршуулсан байдал - 100%

19	Төрийн аудитын байгууллагын audit.mn цахим хуудасны “Ёс зүйн дэд хороо” цэсэд цаг үеийн үйл явдлын тойм мэдээ болон иргэн, шалгагдагч этгээдээс ирүүлсэн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг нэгтгэн дүгнэж оруулах	2025.01.02 2025.03.31	2025.04.01 2025.06.30	2025.07.01 2025.09.30	2025.10.01 2025.12.29	Батлагдсан төсвийн хүрээнд	П.Цэнгүүн МТНТ ТГ	1)ТАБ-ын цахим хуудаст байршуулсан мэдээллийн тоо	ТАБ-ын албан ёсны audit.mn цахим хуудасны “Ил тод байдал” цэсэд “Ёс зүй” нэртэй дэд цэсийг үүсгэж мэдээллийг тухай бүр оруулсан.	ТАБ-ын цахим хуудаст байршуулсан мэдээллийн тоо-4
20	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг бэлтгэж Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулах				2025.12.01 2025.12.26	Батлагдсан төсвийн хүрээнд	Ц.Наранчимэг П.Цэнгүүн	1)Ёс зүйн дэд хорооны ажиллах журам 2) Танилцуулсан материалын тоо	0	Ёс зүйн дэд хорооны тайланг МУ-ын Ерөнхий аудиторт танилцуулсан байна.

-oOo-

Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгтгэл

№	Арга хэмжээний хүрээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	I улирал	II улирал	III улирал	IY улирал
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоох	4	2	3	1	1
2	Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх	6	4	4	4	4
3	Зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах	1	1	1	1	1
4	Албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ, судалгаа хийх	4	1	1	1	1
5	Ёс зүйн зөрчлийг бүртгэх, тайлагнах, мэдээлэх	5	4	3	3	4
Нийт		**20**	**12**	**12**	**10**	**11**